



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 1766

Хараат

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх,
оролцоог хангах орон тооны бус дэд
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4, 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамгаалах тухай хууль, төрийн бодлогын хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах чиг үүрэг бүхий орон тооны бус дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дэд зөвлөлийн дарга: -Засаг даргын орлогч

Гишүүд: - Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

-1 дүгээр багийн Засаг дарга

- Нийгмийн даатгалын байцаагч

Нарийн бичгийн дарга: -Нийгмийн бодлогын мэргэжилтэн

2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний соёл, боловсрол, эрүүл мэнд, биеийн тамир, хөдөлмөр эрхлэлт, хувь хүнийг хөгжүүлэх, эрх чөлөөг хүндэтгэх талаар олон талт үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэнд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН

